

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2025.01.03
Улиастай

Нэг. Нийтлэг үндэслэл


“Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2018 оны А/520 дугаар захирамжаар батлагдсан “Нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт болон нутгийн захиргааны байгууллагуудад иргэдээс бичгээр болон амаар, цахимаар гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэн төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй хүргэн ажиллаж байна.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга нар хуваарийн дагуу иргэдтэй биечлэн уулзаж, өргөдөл, гомдлыг амаар болон бичгээр хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн хариуг хүргүүлж байна.

Иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах 7046-1212 утсыг 24 цагаар ажиллуулж, ирүүлсэн санал, гомдлыг 7 хоногийн дотор шийдвэрлэн хариуг хүргүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Хоёр. Өргөдөл, гомдол хүлээн авсан хэлбэр, бүртгэл

Аймгийн Засаг даргад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлыг төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн систем (erp.e-mongolia.mn) -ийн өргөдөл хэсэгт бүртгэж, удирдлагын шийдвэрийн дагуу албан хаагчдад цахимаар шилжүүлэн шийдвэрлэлтийг хангуулан ажиллаж байна.



Аймгийн Засаг даргад 2024 оны байдлаар 161 иргэн хандаж бичгээр өргөдөл гомдол гаргаснаас 10 нь өргөдөл, 151 нь хүсэлт байна.

Гомдлыг агуулгын хувьд авч үзэхэд газрын асуудалтай холбоотой 6, төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн байгууллагын үйл ажиллагаатай

холбоотой 4 гомдол байна.

Сумын Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын дарга, эрхлэгч нарт хандаж ирүүлсэн 4 мэдэгдэл, 120 гомдол, 17 санал, 1042 хүсэлтийг гаргаж, төрийн байгууллагад 1183 иргэн асуудлаа шийдвэрлүүлэхээр хандсан байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт (хэлбэрээр)

(Хүснэгт

2)

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс:					
			Биеэр	Албан бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	11-11 төвөөр	Бусад
1	Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар	161	161	-	-	-	-	-
2	Нутгийн захиргааны байгууллага	1022	508	71	250	193	0	-
Жилийн эцсийн дүн		1183	669	71	250	193	0	-

Гурав.Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн агуулга

Аймгийн Засаг даргад ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдлыг агуулгын хувьд ангилан үзэж, бүртгэл мэдээллийг хөтлөн шийдвэрлэсэн.

(Хүснэгт 3)

Асуудлын нэр	Нийт тоо	Нийт хувь
Газрын харилцаатай холбоотой	28	17.3%
Төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой	41	25.4%
Дэмжлэг, тусламж хүссэн	67	41.6%
Эрчим хүчний системтэй холбоотой	6	3.7%
Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээтэй холбоотой	13	8.0%
Байгаль орчинтой холбоотой	6	3.7%

Дээрхээс харахад дэмжлэг, тусламж хүссэн иргэдийн өргөдөл дийлэнх хувийг эзэлж байна. Үүн дотроо санхүүгийн дэмжлэг, эмчилгээний төлбөр, түлээ нүүрсний үнэ, гэр хүсэх зэрэг өргөдлүүд хамаарч байгаа бөгөөд 19 иргэн гэр хүссэн байна.

Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд сурталтай холбоотой 15 өргөдөл, гомдол ирсэнг бүртгэн, тухай бүрт шийдвэрлэн ажиллалаа. Ирсэн өргөдөл гомдлоос дийлэнх хувийг эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны хүнд суртал эзэлж байгаа тул холбогдох шатны удирдлагуудад мэдээлэл чиглэл өгч ажилласан байна.

Иргэдийн гаргасан гомдлын дийлэнх хувийг буюу 71.6 хувийг е-баримт олгоогүй, хуулийн хугацаанд баталгаажуулаагүй гэсэн гомдол эзэлж байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

(Хүснэгт 1)

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт хувь
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн		
1	Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар	161	154	-	3	7	95.6
2	Нутгийн захиргааны байгууллага	1022	982	4	17	19	97.06
Жилийн эцсийн дүн		1183	1136	4	20	26	96.0

Иргэдээс тусламж хүссэн өргөдөл ирүүлснийг аймаг, сумын Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс шийдвэрлэж, тусламж дэмжлэгийг үзүүлсэн. Аймгийн Засаг даргын нөөц сангаас 50.7 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.

Байгууллагад шинээр ажилд орох, хөдөлмөр эрхлэхтэй холбоотой асуудлаар иргэд өргөдөл гаргасныг Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, тухай байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд шийдвэрлэн ажилласан.

Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газар өмчлөх, эзэмших, газрын гэрчилгээ гаргуулах, эрхээ шилжүүлэх зэрэг Газрын харилцаатай холбоотой асуудлаар иргэд хандсаныг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт шилжүүлэн шийдвэрлэсэн.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР